



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/17

Улаанбаатар хот

Улаанбаатар Театр ОНӨТҮГ-ын
эргэлтийн бус хөрөнгийг данснаас
хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 12,639,589 (арван хоёр сая зургаан зуун гучин есөн мянга таван зуун наян ес) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Улаанбаатар Театр ОНӨТҮГ (Р.Мөнхсайхан)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 12,639,589 (арван хоёр сая зургаан зуун гучин есөн мянга таван зуун наян ес) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгаж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Улаанбаатар Театр ОНӨТҮГ (Р.Мөнхсайхан)-т зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.



ДАРГА

М. БАЯРАА



Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын
2022 оны 02-р сарын 01-ны өдрийн
А/12 дугаар албан бичгийн хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Улаанбаатар Театр ОНӨТҮГ

д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	ЭБХХК-н шийдвэр
Тавилга, эд хогшлын дүн											
1	Гадна лого	6	ш	1	2,734,589	2,734,589	2,734,589	-	Байгууллагын нэр солигдсон	Актлах	Актлах
2	Гадна хаяг	6	ш	1	8,800,000	8,800,000	8,800,000	-	Байгууллагын нэр солигдсон	Актлах	Актлах
Тавилга, эд хогшлын дүн					11,534,589	11,534,589	11,534,589	-			
Бусад үндсэн хөрөнгө											
1	Бүжгийн цагаан гутал	6	ш	13	85,000	1,105,000	1,105,000	-	Урагдсан	Актлах	Актлах
Бусад үндсэн хөрөнгийн дүн					85,000	1,105,000	1,105,000	-			
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн					11,619,589	12,639,589	12,639,589	-			
Үүнээс. Худалдах хөрөнгө											
Актлах хөрөнгө							12,639,589				
Татан төвлөрүүлэн хөрөнгө											
Худалдсанаас олох орлого											
НӨХГ-т төвлөрүүлэх /30%/											